



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 01385

Улаанбаатар хот

Д.Гантэмэрт сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.5, 37 дугаар зүйлийн 37.1, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.8, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.4 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7, 17.1.8 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 3.4.1, 6.1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1, 10.9, 10.10.3, 10.10.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Доржийн Гантэмэр нь Төрийн албаны тухай хууль, Улсын бүртгэлийн хууль тогтоомж, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журмыг зөрчин, бүртгэл хөтөлсөн нь Хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2024 оны 2788 дугаар дүгнэлтээр тогтоогдсон тул түүнийг 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрөөр тасалбар болгон төрийн албанаас халах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Д.Гантэмөрийн 578 дугаартай улсын бүртгэгчийн тэмдгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Д.Гантэмөрийн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Иргэний улсын бүртгэлийн газар /Т.Төгөлдөр/-т даалгасугай.

4. Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг сануулахыг нууц хамгаалах ажилтан /Г.Анхныбаяр/-д үүрэг болгосугай.

5. Д.Гантэмөрийн ажлыг зохих журмын дагуу хүлээлцэхийг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /Б.Төгс-Эрдэнэ/-т, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

6. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

